

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ ХИЙСЭН ТУРШЛАГААС

Ц.Дамдинсүрэн

Эрдэм шинжилгээний ажлыг хийж байгаа хүмүүсийн авъяас билэг ялгавартай, арга барил олон янз байх учир би ажлыг тэгж хий, ингэж хий гэж зааварлаж номлох явдлыг тусгүй гэж үзэж байна. Би харин өөрийн хийж байгаа ажлын арга туршлагыг яривал уншиж сонсох хүмүүс өөрсдөө зөв бурууг шүүж бодоод таарахыг авах, таарахгүйг орхиход тус болж болох юм. Ийм учраас би өөрийн ажлын арга туршлагаас энэ удаа нэг зүйлийг ярья.

Карт хийсэн туршлага

1946 оны намар би Ленинград Дорно дахиныг судлах хүрээлэнд аспирант болж оров. Эхлээд дэд эрдэмтний зэрэг горилох эрхийн шалгалтыг өгсөөр нэг хоёр жил өнгөрөв. Чухамхан эрдэм шинжилгээний ажлыг 1948 оноос эхэлж хийв. “Гэсэрийн тууж”-ийг дэд эрдэмтний зэрэг горилох зохиолын сэдэв болгож авав. Гэвч юунаас эхэлж яаж судлахыг мэдэхгүй байлаа. Тэгээд урьд танилцсан эрдэмтэн Н.В.Кюнерт очиж “Гэсэр”-ийг судлалын сэдэв болгож авсан боловч юунаас эхэлж, яаж судлахаа мэдэхгүй байна гэж үнэнээ хэлэв. “Эх бичгийг унших, түүнийг урьд судалсан хүмүүсийн ном өгүүллийг унших, энэ хоёр ажлыг юуны өмнө хийх хэрэгтэй” гэж тэр өвгөн багш надад хэлэв. Тэгээд гуйсан ёсоор Н.В.Кюнер Гэсэрийн тухай номын бүртгэлийг хэд хоногийн дараа хийж өгөв. Тэр бүртгэлд заасан номуудыг захиалж номын санд суугаад уншаад байлаа. Хэдэн сар болоход олон арван ном үзсэн байв. Гэвч ямар номонд юу гэж байсныг сүүлдээ би тэр бүр мэдэхгүй, ихэнхийг мартсан буюу хооронд нь хутгасан байв. Урьд үзсэн номоо дахин үзэх шаардлагатай болов. Номыг зүгээр л уншаад байх ашиг багатай, уншсан номын дотроос чухал зүйлийг тэмдэглэж авах хэрэгтэй гэдгийг ойлгов. Тэгээд номын санд зузаан дэвтэр авч очоод дэвтэртээ уншсан номын дотроос чухал гэж санасан зүйлээ тэмдэглэж аваад байлаа. Бас хэдэн сар болоход хэдэн зузаан дэвтэртэй болов. Гэвч тэр дэвтрүүдэд ямар ч дэс дараа байхгүй, аль уншсан номоос аль сонирхсон мэдээгээ бичсэн болохоор түүнээс тухайн үед хэрэглэгдсэн зүйлийг олж авахад тун хэцүү байлаа. Нэг өчүүхэн мэдээг олохын төлөө бүх дэвтрүүдийг дахин дахин унших хэрэгтэй болж өдий төдий цагийг дэмий үрдэг боллоо. Тэгээд байж байтал Ленинградын эрдэмтэн нарын ордонд академич В.М.Алексеевыг лекц унших юм гэнэ гэж сонсоод зарласан цагт нь очив. В.М.Алексеев Хятадын оюуны соёлын тухай сайхан лекц хийв. Тэгтэл нэг хүн “Хятад чөтгөр яагаад улаан үстэй байдаг юм бэ?” гэж асуув. В.М.Алексеев бичгийн саваа нээж олон жижиг цаас картыг гаргаж үзээд энэ тухай тийм эрдэмтэн төдийд тэгж бичсэн, ийм эрдэмтэн өдийд ингэж бичсэн, миний санахад энэ нь буруу, тэр нь зөв гээд тодорхой хариулж байв. Би тэгэхлээр дэргэд сууж байгаа К.М.Черемисоваас асуув. “Алексеев гуай ийм асуулт гарна гэж урдаас мэдээд хариуг бичээд ирсэн хэрэг үү?” гэсэнд К.М.Черемисов надад “Алексеевт хэдэн шүүгээ карт байдаг

юм. Уншсан номоос чухал зүйлийг картанд бичиж аваад сүүлд нь тэр картуудаа хаягаар нь үсгийн дэс дараагээр цэгцэлж шүүгээндээ зохих байранд нь хийдэг юм. Ер нь эрдэмтэн бүрт шахам ийм картын товъёг байдаг” гэж тайлбарлаж хэлэв. “Танд карт бий юу?” гэсэнд “Бий. Та үзэж болно” гэв. Сүүлд нэг өдөр К.М.Черемисовын гэрт очиж карт товъёогтой нь танилцав. Картыг яаж хийдэг, яаж эмхэлдгийг бараг мэдэж авлаа. К.М.Черемисов яагаад өвөр дүүрэн картын цаастай явдаг учрыг ч мэдэж авлаа. Үүнээс хойш би уншсан номын доторх чухал мэдээг дэвтэр дотор бичихээ болиод жижиг карт дээр бичдэг болсон. Карт дээр заавал нэр хаягийг бичих хэрэгтэй. Ингэвэл сүүлд картыг цэгцлэхэд амар байдаг. Картыг аятайхан хийж, сайн эмхэлж чадвал их тустай зүйл юм. Ялангуяа над шиг мартагдахуй хүнд ганц лавлах түлхүүр болж өгнө.

Зөвлөлт улсын зарим эрдэмтэн цаасыг зохих хэмжээгээр хэрчүүлж карт бэлтгэдэг. Зарим эрдэмтэн бэлэн картыг соёлын барааны дэлгүүрээс худалдаж аваад хэрэглэдэг байна. Би бол ердийн бичгийн машинд хэрэглэдэг 30х22 см хэмжээний цаасыг хоёр нугалж огтлоод дөрвөн карт болгож хэрэглэдэг. Карт дээр ном уншихын далимд чухал зүйлийг тэмдэглэж авахаас гадна, хүний ярьсан хэлсэн зүйлийг ч мөн тэмдэглэж авдаг. Ингээд надад үсгийн дэс дараа ба сэдвээр ялгасан хэдэн шогол карт бий. Гэсэрийн туужийн тухай, тэнгэрийн дагинын үлгэрийн тухай, Шамбалын тухай карт үлэмжхэн олон болсон учир түүнийг дотор нь ангилж тусгай шоголд хийсэн, бусад картуудыг үсгийн дэс дараагаар эмхэлж нийтийн шоголд хийгээд хадгалж байдаг. Үүнээс хэрэгтэй зүйлийг авч үзээд эргүүлж хийдэг. Энэ картнаас заримыг авч үзүүлье.

Тэрэг хэмээх картаас

Эргэдэг дугуйг (хүрдийг) хэрэглэх болсон нь хүн төрөлхтний соёлын гайхамшигт амжилтын нэг болно. Монгол, Зөвлөлтийн хамтарсан шинжилгээний анги 1962 онд Өвөрхангай аймгийн Ховд сумын нутаг Тэвш уулын хаданд бичсэн олон зургийг нээж олсон байна. Эдгээр зургийн дотор дөрвөн морь хөллөсөн дөрвөн дугуйтай тэрэгний зураг байна. Энэ зургийг манай он тоолол эхлэхээс хэдэн зуун жилийн өмнө үйлдсэн гэж Д.Дорж бичсэн билээ (1969:38). Энэ бол Төв Азийн нүүдэлчин аймгууд, түүний дотор багтсан монгол аймгууд маш эрт цагаас тэрэг хэрэглэж байсны баримт болно.

Дугуйг хуучин монгол хэлэнд хүрд гэдэг. Дугуй хүрдийг төвдөөр хорол гэдэг. Хорол гэдэг үг монгол хэлэнд бас оржээ. Монгол хүн хүрдийг эрхэмлэн хүндэлж байсныг олон баримтаас олж болно. Энэтхэг, Төвдөөс уламжлалтай найман тахилын нэг нь хорол байдаг. Найман тахил бол аж амьдралын чухал хэрэгцээний найман эдлэл байдаг. Жишээ нь нар борооноос халхлах шүхэр, арга билиг хослох амьдралын бэлгэ тэмдэг хоёр загас, хумх хэмээх усны сав, ургамал цэцэг, дуугаар холоос дохио өгөх лавай, аргамж дээс оосрын тэмдэг өлзий утас, туг, хорол найм болно. Монголчуудын “12 жил” буюу “Хорол” гэдэг тоглоомын дотор эрхэм суурийг хорол эзэлдэг. Хорол бол тэрэгний дугуйн чимэглэсэн хуулбар дүрс болно.

Монголчууд олон янзын тэргийг хийж хэрэглэдэг. Энэ соёлын их ололт, аж амьдралын чухал хэрэгслийг хийх, эдлэх уламжлалыг орхихгүй, улам хөгжүүлэх хэрэгтэй. Монгол хүн тэгээд тэргээ мэддэг, хүнд ярьж чаддаг байх хэрэгтэй. Энэ талаар Ардчилсан Герман улсад очсон үед надад тохиолдсон нэг явдлыг хэлэхийг хүсэж байна.

Би 1977 оны өвөл Ардчилсан Герман улсад эрдэм шинжилгээний томилолтоор очиж хориод хоног ажилласан билээ. Ихэнх цагаа номын санд сууж ном уншиж өнгөрүүлэв. 1977 оны 12-р сарын 9-ний өдөр би Лейпциг хотод Этнографийн (зан суртахууны) музейн номын санд сууж эрдэмтэн Шубертын номын цуглуулгыг үзэж байв. Тэгтэл миний танил, Зөвлөлтийн эрдэмтэн Вайнштейн орж ирээд “Энд монгол гэрийн хачин тооно байна. Тэр тооныг хэдэн монгол хүнээс асуухад мэдэхгүй байсан гэнэ. Та түүнийг үзэж тайлбарлаж

өгөөч” гэв. Би түүнийг дагаад музейн фондод оров. Фондын эрхлэгч, нярав гэх мэтийн хэдэн хүн тэнд байв. Надад дорнод Монголд эдэлдэг хуруутай тоонын эвдэрхий үзүүлэв. Би тийм тоонотой гэрт өссөн хүн учраас тэр тооныг тайлбарлаж өгөв. Би оросоор ярьж, Вайнштейн орчуулж байв. Тэр тоононд унийг яаж хэлхдэг, нүүхдээ яаж тэргэнд ачдаг, яаж угааж цэвэрлэдэг, тоонын хэсгүүдийг юу гэж нэрлэдэг зэргийг ярьж өгөв. Тэд сонирхон сонсохоор барахгүй, бичиж зурж авлаа. “Энэ хачин тооныг мэддэг хүн олдлоо” гээд тэд баярлаж, намайг хүндэлж байна. “Аа, энэ их юм мэддэг хүн” гээд хоорондоо ярьж байна.

Тэд монгол тэрэгний тухай бас надаас суув. Би монгол тэрэгний тухай ярьж эхлэв. Монгол тэрэг хоёр үндсэн ялгаатай байдаг. Хангайн уулархаг нутагт их төлөв тэнхлэгээр эргэдэг тэргийг эдлэдэг. Тал говь нутагт их төлөв дугуйгаар эргэдэг гээд ярьж байлаа. Тал говийн тэрэг бол хэрчмэл 6 мөөртэй, мөөрийг хоноодсоор тогтоодог, мөөр бүр 3 хигээстэй, нэг дугуйд их төлөв 18 хигээс байдаг. Тэрэгний цун жанг хаана нь суулгадаг, чихийг тэнхлэгт яаж тогтоодог, аралд хэдэн ялуу байдаг гэх зэргийг тоочин ярилаа. Тэд их сонирхон сонсож байна, зарим нь бичиж зурж байна. Их цас ордог тал нутагт бүтэн хагас метр хэр өндөр дугуйтай цүүвэн (цүүвгэр) тэргийг эдэлдэг гээд ярьж байснаа би мэдэхгүй зүйлд тулгарч түгдэрч эхлэв. Цүүвэн тэрэг матмал мөөртэй байдгийг мэдэх боловч мөөрийг нэг бүхэл модоор хийдэг буюу хоёр гурван хэсэг модоор хийдэг алин болохыг мэдэхгүй байлаа. Дугуй нь хэдэн хигээстэй байдгийг бас мэдэхгүй байлаа. “Мэдэхгүй” гэж тэдэнд үнэнээ хэллээ. Ард олны үргэлж хэрэглэдэг тэргийг би сайн мэдэхгүй байсандаа гэмшив. Германаас Монголд буцаж ирснээс хойш тэрэгний мөөр, хигээсний асуулт миний санаанд үргэлж хоногшиж, сэтгэл амруулахгүй байлаа. 1978 оны шинэ жилийн нэгний үдэш Улаанбаарт бид хэдүүл нэг айлд оров. Тэнд хоол идэж, архи дарс амсаж хүндлүүлэв. Би жаахан сууж байгаад явах гэсэнд нөхөд маань “Хамт гаръя” гээд явуулахгүй байв. Тэгэхлээр би Готов гэдэг өвгөнтэй хэдэн үг сольж байтал тэр маань барга гаралтай хүн байв. Би бүр олзуурхаж, “Баргад тийм өндөр дугуйтай тэргийг цүүвэн тэрэг гэдэггүй, шар дугуйт гэж нэрлэдэг. Шар дугуйтыг Хянганд бодхон (анчин) дагуур нар хийж Хайлаарт авчирч худалддаг байсан. Хоёр хэсэг модоор хийсэн матмал мөөртэй, 22 хигээстэй, булыг хар хусаар хийдэг. Их бөх сайн тэрэг. Тийм нэг тэргийг 60 жил эдэлдэг гэдэг” гэж яриу. Монголын ард түмний эдийн соёлын эрхэм дээж болсон тэрэгний тухай чухал мэдээг олж цагийг ашигтай өнгөрүүлсэндээ би их баярлалаа. Би баярлаад амандаа шүлгийн хэдэн мөрийг хэлхэж эхлэв.

Хоёр матмал мөөртэй тэрэг
Хорин хоёр хигээстэй тэрэг
Холбоо арван ялуутай тэрэг
Хос өндөр дугуйтай тэрэг
Хорол эрдэнийн шинжтэй тэрэг
Холын аянд зохистой тэрэг
Хотол олонд магтаалтай тэрэг
Хорвоо ертөнцөд алдартай тэрэг
Хонгор морь нь шогшиж байна
Хорол дугуй нь эргэж байна
Холын газар ойртож байна
Хоногийн газар дөхөж байна
Ай хөө, ай хөө, явна даа
Алсын замыг туулна даа.

Би шүлгээ дутуу орхиж босоод, баярласандаа бүжиг хийж эхлэв. Тэд намайг баярлаад бүжиг хийж байгааг мэдэхгүй, согтоод бүжиг хийж байна гэж бодсон байх ч магадгүй. Шөнө

гэртээ ирээд би карт дээрээ шар дугуйт тэрэгний дугуйг зурж тайлбарыг бичиж үлдээв. Ер нь амьдралыг ажиглаж, амьдралд идэвхтэй оролцож явах хэрэгтэй. Хүн гэдэг амьтны онцгой шинж нь үүнд оршиж байна. Зүгээр гөлийж явсаар юу ч мэдэхгүй насаа барвал их харамсалтай. Үүнтэй холбогдуулан би нэг зүйлийг ярихыг хүсэж байна.

Би тэр жил говьд явж байгаад нэг тэмээ унасан өвгөнтэй дайралдав. Уулзаад ярив. Тэр өвгөн ярьж байна “Сая аймгийн төвөөс манай бригад дээр дуучин, хөгжимчин, үлгэрчин арваад хүн ирж их сайхан юмыг үзүүллээ. Би түүнийг үзээд буцаж явна. Олон хүн цугласан учир би тэмээгээ унаж зогсож байгаад үзлээ” гээд ийм хүн тийм дууг дууллаа. Тийм хүн тийм үлгэр хэллээ. Тийм дуу нь манай нтгийн дуунаас жаахан өөр юм гэх зэргээр үнэлэлт, шүүмжлэл, магтаал гурвыг хавсарган ярив. Тэр өвгөний яриаг би сонирхож бахдаж сонсов. Тэгээд тэмээг нь харав. Тэр тэмээ мэлмэлзсэн сайхан нүдтэй боловч юу ч харж сонирхсон байдалгүй байлаа. Хүн, тэмээ хоёул уран сайхан зүйлийг үзсэн боловч хүн нь нарийн учрыг мэдэж сонирхсон, тэмээ нь уран сайхныг үзээгүйтэй адил, юу ч сонирхохгүй, юу ч мэдээгүй буцаж явлаа. Тэгэхлээр бид хүн шиг юмыг сонирхож мэдэж явбал сайхан, тэмээ шиг юу ч мэдэхгүй, юуг ч сонирхохгүй гөлийж явбал муухай.

Монгол үсгийн тухай картаас

“Монгол үсэг” гэсэн хаягтай хэсэг картыг авч үзье. Уйгуржин монгол үсгийн долоон эгшиг үсгийн дэс дараа нь: *а, э, и, о, у, ө, ү* болно. Эдгээр үсгийг дуудаж уншихдаа өмнөө толь тавьж уруул амны хөдөлгөөнийг ажиглаж үзээрэй. *а, э, и* гурвыг хэлэхэд амны хөндий анх их байгаад улмаар явцуурч ирнэ. *о, у, ө, ү* дөрвийг хэлэхэд уруул анх төгрөг байгаад улмаар цорвойж явцуурч ирнэ. Энэ долоон эгшигийг дуудахад амны хөндий уужим байгаад улмаар явцуурч уруул цорвойж хамгийн сүүлд *ү* үсгийг дуудахад бүр явцуурна. Тэгэхлээр долоон эгшигийг эрдэм шинжилгээний маш нарийн мэдлэгтэй хүн дараалж бичсэн байна. XIV зууны үед Чойжи-Одсэр энэ мэргэн дарааллыг хийсэн байж болно. Эсвэл Чойжи-Одсэрээс урьд монгол үсгийг уйгураас авах үед энэ дарааллыг хийсэн байж болно. Уйгураас энэ дарааллыг авсан болов уу гэхэд уйгур үсэгт эгшиг үсгийн ийм дараалал байгаагүй, уйгур үсгийн дараалал одоо олдож байгаа баримтаас үзэхэд бүр өөр дараалалтай байсан байна. Тэгэхлээр эрдэм шинжилгээний үндэстэй долоон эгшиг үсгийн дарааллыг монголчууд өөрсдөө хийсэн гэж дүгнэж болмоор байна. Үүнд ганц эргэлзэх зүйл бий. Тэр нь аль вэ? гэхэд кирилл эгшиг үсгийн дараалал болно. Одоо бидний хэрэглэж байгаа кирилл орос үсгийг тогтсон дарааллаар бичээд түүнээс бүх гийгүүлэгч үсгүүдийг баллаад үзвэл *а, э, и, о, у* таван эгшиг үлдэнэ. *ө, ү* хоёр эгшиг орос славян хэлэнд байхгүй учраас үсэгт нь байхгүй. Энэ таван эгшигийн дарааллыг үзвэл өнөөх манай уйгуржин монгол үсгийн эгшигийн дараалалтай тохирч байна. Яагаад ийм байна вэ? Орос, славян, латин, уйгур, согд үсгийн нийтийн үүсгэл болох финик үсэгт эгшиг үсгийн тийм нарийн дараалал байсан байж магадгүй гэж санагдуулж байна. Ямар ч болсон эрдэм шинжилгээний үндэстэй долоон эгшигийн дараалал дэлхийн олон үсэг бичгийн дотроос зөвхөн уйгуржин монгол бичигт үлдсэн нь монголчуудын эртний соёлын өрнөлтийн хэмжээг үзүүлэх сайхан баримт болно. Далимд хэлэхэд санскрит, төвд үсэг бол мөн эрдэм шинжилгээнд үндэслэсэн нарийн дараалалтай болно.

Бас *д, т* үсгийн тухай картыг авч үзье. Уйгуржин монгол бичигт *д, т* хоёр үсэг байдаг. Гэвч үгийн эхэнд *д* үсгийг *т* үсгээр бичдэг, үгийн дунд *т* үсгийг *д* үсгээр бичдэг. Ингээд *д, т* үсэг бие биеэ сольж хутгалдаж явдаг болсон юм. *Дотор* гэдэг үгийг *додор, дотор, тодор* гэж янз янзаар уншиж болохоор бичдэг билээ. Тэгэхлээр өгүүлбэрийн утгаар нь *дотор, тодор* гэж алинаар уншихыг таамаглаж мэддэг байлаа. *д, т* үсгийг сонгодог бичгийн хэлний өмнөх үеийн зарим дурсгалд ялгаж бичихийг оролдож байсан удаа байх боловч энэ оролдлого их дэлгэрч чадаагүй орхигдсон байна. Монголчууд *д, т* үсгийг хутгаж бичдэг

болсон нь уйгур бичгийн уламжлалыг яг мөрдсөнөөс болсон гэж зарим хүмүүс боддог байсан. Гэтэл миний бие 1977 оны өвөл Берлин хотод очоод Турфаны цуглуулга хэмээх IX-XII зууны үеийн уйгур бичгүүдийг үзвэл *д*, *т* хоёр үсгийг тодорхой ялгаж бичиж байжээ. Тэгэхлээр монголчууд *д*, *т* үсгийг хутгаж бичих явдлыг уйгураас уламжилж авсан биш, харин монгол хэлэнд *д*, *т* авиа харилцан хутгалдан хэлэгддэг байсны нөлөөгөөр хутгалдуулан бичдэг болсон байж магадгүй. Ер нь цаашдаа энэ асуултыг сайн судалж үзэх хэрэгтэй гэдэг саналаа картдаа бичсэн билээ.

Монгол үг гэдэг картаас авч үзье

Хуучин ном бичиг бол Монголын соёлын дурсгал болохоос гадна монгол хэл бичгийн судлалд тодорхой ач холбогдолтой чухал материал болдог билээ. Багш Д.Цагаан 1950-аад онд Хөвсгөл аймгаас монгол “Үлгэрийн далай” хэмээх судрыг олжээ. Түүнийг уншиж үзлээ. Гэтэл тэр ном бол нийтэд дэлгэрсэн “Үлгэрийн далай”-аас өөр орчуулга байлаа. Нийтэд дэлгэрсэн “Үлгэрийн далай” бол гүүш Цоржийн орчуулга юм. Д.Цагааны олсон “Үлгэрийн далай” бол Авгын Цүлтимлодойн орчуулга байлаа. Энэ “Үлгэрийн далай” бол өөр орчуулга болохын хувьд сонирхолтой болохоос гадна, хэл нь их сонирхолтой байлаа. Цүлтимлодойн энэ судрын дотор *нама-ача*, *нада-дур* гэхийн оронд *нима-ача*, *нима-дур* гэж бичсэн байв. Монгол хэлний биеийн төлөөний нэрийн ганц тоонд язгуурын эгшиг нь ямагт и байдагтай энэ *нима* гэдэг хэлбэр чухамхан зохицож байна. Жишээ нь: *би > нима-дур*, *чи > чима-дур*, *и > има-дур* гэх мэт. Монгол хэлний гуравдугаар биеийн төлөөний нэрийн ганц тооны *и* хэлбэр нь мартагтаад одоо зөвхөн харъяалахын тийн ялгалын *ину*, нь хэлбэр үлджээ. Харин монгол хэлний биеийн төлөөний нэрийн олон тоонд язгуурын эгшиг нь ямагт “*а*” байдаг билээ. Жишээ нь: *ба > ман-дур*, *та > тан-дур*, *а > ан-дур* гэх мэт. Монгол хэлний гуравдугаар биеийн төлөөний нэрийн олон тооны *а* хэлбэр нь одоо мартагдаад зөвхөн *ану*, нь хэлбэр үлджээ. XV зууны үед Мукаддимат ал-Адабын зохиосон “Араб-монгол толь бичиг”-т *нама-дур*, *нада* гэхийн оронд *нида* гэж бичсэн удаа бий. Тэгэхлээр язгууртаа *и* эгшигтэй *нима-ача*, *нима-дур* гэдэг нь ганц тоог үзүүлсэн нэгдүгээр биеийн төлөөний нэрийн хэлбэр бөгөөд харин *нада-ача*, *нама-дур* гэдэг нь язгууртаа *а* эгшигтэй байгаа тул нэгдүгээр биеийн олон тоог үзүүлсэн хэлбэр байж болох юм. *надаас*, *намайг* гэдгийг *биднээс*, *биднийг* гэсэнтэй адил олон тооны утгаар хэрэглэсэн баримт хуучин ном зохиолоос хараахан олдохгүй байгаа боловч тийм утгаар хэрэглэсэн баримт байх ёстой гэж бодоод түүнийг эрж сурвалжилж байна.

Мөн “Монгол үг” гэдэг хаягтай өөр нэг картыг авч үзье. 1978 оны 4-р сард Налайхад би очиж халзан Дамдин өвгөнтэй уулзаж түүнээс монголоор бичсэн “Ихэд тонилгогч” хэмээх судрыг олж авав. Тэр судрыг уншиж үзвэл их хуучин хэлтэй сонин судар байлаа. Ганц жишээг дурдвал, тэнд бичсэн нь: “Энэ судар хам хамигаа бүгсэн бүгээс” (х.126) гэжээ. Үүний утга нь *энэ судар хаана байсан болбол* гэсэн болно. Энэ өгүүлбэрийн доторх “бүгсэн” гэдэг үг нь “бүгэх” гэдэг үгээс гарсан *бүгсэн*, *нуугдсан* гэсэн үг биш, харин “бүх” (байх) гэдэг үгээс гарсан *байсан* гэсэн утгатай үг болно. Ингэж ном судрыг уншиж хуучирсан үг, хувирсан үгийн хэлбэрийг шүүрдэн олж карт дээрээ бичиж байна.

Монгол эмэгтэй гэдэг картаас

“Монгол эмэгтэй” гэдэг хаягтай хэсэг карт байна. Үүний дотор Даваажав гэсэн хаягтай картыг авч үзье. Эмэгтэй Даваажав бол Ленинтэй биеэр учирсан ганц монгол эмэгтэй юм. Даваажавыг Ленинтэй учирсан тухай “Эмэгтэйчүүд” сэтгүүлийн 1964 оны 2-рт бичсэн зүйл бий. 1921 онд Даваажав нөхөр Лосолын хойноос Москвад очоод Монголын залуучуудын төлөөлөгчдийн хамт их театрт бүжиг үзэж байхад Ленин орж ирээд Даваажавтай мэндлээд

өмссөн монгол дулаан дээлийг сайшааж “Өнөөдөр театрт хүйтэн байна. Таны дээл яг тохирч байна. Монголын эмэгтэйчүүд ингэж олон нийтийн хэрэгт оролцож яваа нь сайшаалтай” гэж хэлсэн гэдэг. Бодвол торгон дээл өмссөн монгол эмэгтэй содон харагдаж дэргэдүүр нь гарахдаа анхаарч мэндэлсэн хэрэг биз. Даваажав Ленинтэй учирсан хүн болох тул түүний тухай мэдээ дайралдвал би картдаа бичдэг болсон юм.

Олноо өргөгдсөний гуравдугаар (1913) оны 12 сард Богд хаанаас хишиг хүртээн өргөмжлөл олгохыг гуйсан бичгийн дотор “Хурц бэйс Түддэнгийн дараа авсан хатан Даваажав энэ жил 21 нас, урианхад овогтой, төрхмийн эцгийн нэр Цэрэнпунцаг, урианхад овогтой болно” гэжээ. Үүнийг архивын данснаас хуулан авав. Даваажав 1913 онд 21 настай байснаас үзэхэд 1893 оны могой жил төрсөн байна. Даваажав 1970 онд нас баржээ. 1975 онд Сүхбаатар аймгийн 80 гаруй настай Лхаа гэдэг эмгэнтэй уулзаж ярилцав. Тэр эмгэн урьд залуудаа Богдод мөргөх гэж Их Хүрээ рүү тэмээн хөсгөөр аялж явжээ. Замд нь хөх бөхөвтэй тэмээтэй хэсэг аянчин буусан байжээ. Хөх бөхөвтэй тэмээтэй байхыг үзвэл жирийн аянчин биш гэж Лхаатай хамт явсан хүмүүс бодож, тэр аянчны ойр буугаад нэг нь очиж уулзжээ. Зэргэлдээ хошууны Хурц ван ноён хүрээнээс авсан хатнаа дагуулаад нутагтаа буцаж яваа нь тэр байжээ. Лхаа хүрээ хүүхнийг үзнэ гэж очиж харсан гэнэ. Тэгэхэд дугуй цагаан царайтай, залуухан, хөөрхөн хатан байсан гэж ярьсан билээ. Хурц ван Түддэн эрдэм чадалтай боловч догшин хэцүү хүн байсан тул Даваажав хамт суух аргагүй болоод ганц морин унаатай оргож аянчин дагаад Их Хүрээнд ирсэн гэдэг. Даваажав сүүлд партизан Лосолын эхнэр болж олон жил хамт амьдарсан билээ. Даваажавын тухай би өгүүлэл бичих зорилгогүй боловч хэрэг болж магадгүй гэж бодоод дайралдсан мэдээг картад бичиж байдаг. Цааш нь “Монгол эмэгтэй Хорлоо” гэдэг карт байна. Хорлоо бол Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын зочид буудлын ажилтан эмэгтэй билээ. Би Хорлоотой 1975 оны зун Шаргалжуутын амралт дээр танилцсан. Энэ эмэгтэй ямар ч сургууль хийгээгүй хөдөөний малчин эмэгтэй боловч түүний нүүр хагарсан цовоо сэргэлэн байдал нь миний анхаарлыг татаж карт дээр бичигдсэн юм. Би нэг өдөр амралтын байраас гарч Лхам гэдэг рашаанаас уух гэж зүүн хойш чиглэж нэгдлийн амралтын хажуугаар явж байтал урьд таних эмэгтэй Хорлоо намайг дуудаж байна. Очлоо. Арваад эмэгтэй цуглаад хууч хөөрч байгаа юм шиг байна. Хорлоо надаас гуйв: “Та бидэнд нэг сонин юм ярьж өгөөч” гэв. Би хэлэв: “Өө би амжихгүй. Хоолноосоо өмнө рашаан уух гэж яарч явна” гэв. “За тэгвэл богинохон шүлэг ч хамаагүй уншиж өгөөч” гэв. Тэд нэгд, хийх ажилгүй жаахан уйдсан байна. Хоёрт, би тэдэнд ганц хоёр удаа юм ярьж өгсөн учраас тэгж нүүрэмгий надаас гуйж байна. Би “Юү хэлдэг билээ?” гэж бодлоо. Тэгтэл миний төвдөөс орчуулсан шүлгийн нэг бадаг санаанд оров. Энэ бадаг зарим хүнд таалагддаг юм билээ. Би тэдэнд ингэж уншлаа:

Эрэн бар, цоохор ирвэсийг

Элдэв аргаар номхруулж болно.

Эхнэр гэдэг гээгтэй барыг

Энхрийлэх тутам догшин болно.

Тэд бие биеэ харцгаав. Зарим нь инээв. Зарим нь учрыг сайн ойлгосонгүй бололтой, “Дахиад уншаад аль” гэж гуйж байна. Би дахиж аажимхан уншив. Одоо тэд сайн ойлгоцгоов. Хорлоо нэг л дургүй байдалтай нүдээ ширвэж байна. “Танд таалагдсангүй юу?” гэж би асуулаа. Хорлоо хэлж байна: “Яаж таалагдах вэ! Та эмэгтэйчүүдийг доромжилж байна шүү дээ” гэв. Би хэлэв: “Та намайг эмэгтэйчүүдийг доромжилсон гэж бодож байгаа бол хариуд нь та эрэгтэйчүүдийг нэг доромжилчих. Тэгвэл аваа өгөө тэнцэнэ” гэв. Хорлоо нэг юм хэлэх гээд бодож байх бололтой. Би түүний үгийг хүлээгээд зогсож байв. Хорлоо дөрвөн мөр шүлгийг надаар дахин уншуулаад хэлэв. “Эхнийх нь хоёр мөр ч яахав, зүгээр, сүүлчийнх нь хоёр мөрийг сольж болмоор юм” гэв. “Яаж солих вэ?” гэж би асуув. Тэгэхлээр хэлж байна:

“Эрээн бар, цоохор ирвэсийг
Элдэв аргаар номхруулж болно”

гэдгийн дараа:

“Эр гэдэг гэзэггүй барыг

Энхрийлэх тутам лонхонд тэмүүлнэ гэж хэлж болно шүү дээ” гэв. Би түүнийг аятайхан хоёр мөр шүлэг хэлсэнд баярлаж “Болно болно. Нээрээ тэгж болно” гэв. Тэдэнд “Баяртай” гэж хэлээд би рашаан булаг дээр очиж рашаан уув. Тэнд Хорлоо хүүхний хэлсэн үгийг бодсоор суув. “Архинд дурлана” гэдэг санааг өөр тойруу үгээр “лонхонд тэмүүлнэ” гэж хэлсэн их аятайхан санагдав. Энэ уран шүлэгч хүүхэн байна шүү гэж бахархаж бодов. Тэгээд өвөртөлж явсан картаа гаргаж Хорлоогийн хэлсэн хоёр мөр шүлгийг бичиж авсан билээ. Энэ картын үүсэл гарал ийм байна. Манай улсын иргэд хот хөдөө ялгалгүй нийтээрээ соёлжиж байна. Сэргэлэн цовоо Хорлоо хүүхэн бол манай хөгжлийг илэрхийлэх сайхан гэрч болно. Хорлоо хүүхнийг хуучин цагийн аймхай, бүрэг дорой хүүхнүүдтэй зүйрлэхэд тэнгэр, газар хоёр шиг ялгаатай байна.

“Алтан товч”-ийн тухай картаас

Лувсанданзангийн “Алтан товч” гэдэг Монголын түүхийн чухал ном байдаг. Үүнийг манай Судар бичгийн хүрээлэнгийн анхны дарга Жамъян гүн 1926 онд Дорнод аймгаас олж иржээ. “Алтан товч”-ийг 1937 онд хоёр дэвтэр болгож Улаанбаатар хотод хэвлэж гаргав. Мөн хоёр дэвтрийг яг хэвээр нь хуулж Мостэрт Америкт 1962 онд хэвлүүлжээ. Эрдэмтэн Ж.Цэвээн 1936 онд хэвлүүлсэн “Монгольские летописи XVII века” хэмээх номдоо мөн Алтан товчийг судалж дөчөөд хуудас бичсэн байна (Жамцарано, 1936:79-120). Энэ “Алтан товчийг” Н.П.Шастина 1973 онд орос хэлээр орчуулж судалгааны хамт Москвад хэвлэж гаргасан (Шастина, 1973). Үүнээс гадна “Алтан товч”-ийг орчин үеийн монгол хэлээр Ц.Шагдар орчуулж 1957 онд Улаанбаатарт хэвлэв (Шагдар, 1957). Үүнээс үзэхэд “Алтан товч” эрдэмтэн мэргэдийн анхааралд байнга байгаа чухал түүх болох нь мэдэгдэж байна. “Лувсанданзангийн эмхэтгэсэн “Алтан товч” Монголын түүхийн маш чухал тулгар бичгийн нэг мөн болох нь маргаангүй” гэж Ш.Нацагдорж “Алтан товчийн зохиогчийн тухай” гэдэг өгүүлэлдээ 1958 онд бичсэн юм (1958:53).

“Алтан товч”-д алдарт “Нууц товчооны” ихэнх хэсэг байдаг бөгөөд XVII зууны эхний хагас хүртэлх Монголд болсон явдлуудыг бичсэн юм. Энэ чухал түүхийг судлахад би хувь нэмрээ оруулья гэж аль хэдийн 1950-аад оны үеэс эхэлж оролдсоор ирлээ. Тэгэхдээ тэр зохиолд бичигдсэн түүхт явдлыг би судлах гэж бодоогүй. Харин уг номын үүсэл гарлын тухай судлалд оролцъё гэж шийдээд уг номын тухай хоёр жижиг асуултыг судалж нэг өгүүлэл бичье гэж бодсон юм. Тэр хоёр асуулт нь: нэгд, Лувсанданзан гүүш¹ нь хэдийд байсан ямар хүн бэ? Хоёрт, Жамъян гүн 1926 онд хэнээс тэр номыг олж авсан бэ? гэдэг асуулт юм. Энэ талаар өгүүлэл бичихийн тул юуны өмнө шаардагдах мэдээ материалыг цуглуулж эхэлсэн билээ. Эрдэм шинжилгээний өгүүллийг бичихэд нэгд, материалыг цуглуулах хэрэгтэй; хоёрт, цуглуулсан материалаа судлах хэрэгтэй. Ийм бэлтгэл хийсэн бол сая өгүүллийг бичиж болно. Одоо ямар материалыг яаж сурвалжлан цуглуулснаа өгүүлсүгэй.

“Алтан товч”-ийг зохиогчийн тухай

“Алтан товч”-ийн эцэст бичсэн нь: *“Аяа гайхамшигт хувилгаан богдос хаадын язгуур үндсийг өдий төдий түүхээс аяга тэхэмлиг Шаснадара Лувсанданзан хэмээгдэх гүүш-*

¹ Гүүш гэдэг үг нь утгаа хятадын гуоши (улсын багш) гэдэг үгээс гарсан юм. Энэ цолыг анхандаа хаад эздийн багш дээд лам нарт олгодог байсан боловч сүүлдээ зөвхөн орчуулагч багш хүнд олгодог болсон юм. Гүүш гэдэг цолыг төвд хэлэнд гошри гэж бичдэг заншилтай.

бээр ахуй их улс залган үзтүгэй хэмээн хичээн бичүүлсэн” гэжээ. Үүнд Лувсанданзан гүүш нь хэдийд байсан, ямар хүн болохыг түүхч нар мэдэхийг оролдсон боловч мэдэж чадаагүй байна. Лувсанданзан гүүшийг 1721 онд хэвлэгдсэн “Утайн гарчиг” хэмээх номыг зохиосон Лувсанданзан мөн байх гэж эрдэмтэн Ж.Цэвээн “Монгольские летописи XVII века” хэмээх номдоо бичсэн. Ш.Нацагдорж “Алтан товчийн зохиогчийн тухай” хэмээх өгүүлэлдээ “Алтан товч”-ийн зохиогч Лувсанданзан бол Өвөр Монголын Их зуугийн чуулганы Далад хошууны Дашчойлин хийдийн мэргэний эрхт лхазун Лувсанданзан гэдэг лам байж магадгүй гэж бичсэн байна. Энэ таамаглал зөв ч байж магадгүй, буруу ч байж магадгүй. Ер нь Монголд Лувсанданзан нэртэй лам олон байсан тул Лувсанданзан бүрийг “Алтан товч”-ийн зохиогч гэж үзэж болохгүй. Зохиогч нь нэг л Лувсанданзан байх хэрэгтэй. Харин нэг Лувсанданзанг олохын тул олон Лувсанданзанг судлах хэрэгтэй болж байна.

“Алтан товч”-ийг зохиосон Лувсанданзан нь гүүшри буюу гүүш (орчуулагч багш) цолтой эрдэмтэй хүн байсан тул тэр Лувсанданзанг Монголын ном судар бичих шажны үйл ажилд идэвхтэй оролцож байсан эрдэмтэй лам нарын дотроос эрэх хэрэгтэй гэж эрдэмтэн Ж.Цэвээн, Ш.Нацагдорж нарын бодож байсан нь зөв зүйтэй. “Алтан товч” гэдэг чухал сонин түүхийг бичсэн Лувсанданзан нь “Алтан товч”-оос өөр ном сударт эрхбиш нэрээ үлдээсэн байх гэж таамаглаад монгол Ганжур, Данжур ба бусад ном судрыг орчуулсан зохиосон хүмүүсийн дотроос Лувсанданзан буюу ялангуяа Лувсанданзан гүүш гэдэг хүмүүсийг шүүрдэн авч жагсаая гэж бодоод Лувсанданзан нэртэй хүмүүсийг ном судраас шүүрдэж картлан бичсээр нилээд жил болж байна. Үүнд манай нөхдөөс тусалж зарим картыг бичиж өгсөн зүйл бий. Ингээд Лувсанданзан гэдэг хаягтай олон картаас энд хэдийг сийрүүлж үзүүлье. Юуны өмнө монгол Данжурыг орчуулсан хүмүүсийн дотроос Лувсанданзан нэрийг шүүрдэж олсноо өгүүлье.

Монгол Данжурын 211-р ботид байгаа “Шарибудрийн найман хэсэгт” хэмээх номын төгсгөлийн үгэнд *“Үзэмчин Цэвдэн бэйлийн хошууны гүүшри хэмээгдсэн, үнэгэнд арсланы нэрийг хадсан Лувсанданзан орчуулав”* гэжээ. Монгол Данжурын 211-р ботид байгаа “Байлдаанаас тийн бөгөөд ялгуугч хэмээх тантрисын хаан эгшиг ургахуй” хэмээх номыг мөн лам орчуулж нэрээ *“Үзэмчин Цэвдэн бэйлийн хошууны гүүшри хэмээгдсэн, үнэгэнд арсланы нэр хадсан Лувсанданзан”* гэж бичжээ. Монгол Данжурын 211-р ботид байгаа “Ардыг тэжээхүй дусал нэрт төрийн шастир”-ыг мөн Үзэмчин Цэвдэн бэйлийн хошууны гүүшри Лувсанданзан орчуулжээ. Энэ орчуулгыг бид “Рашааны дуслын монгол, төвд тайлбар” гэдэг номд 1964 онд хэвлэж гаргасан билээ (Дамдинсүрэн, 1964:71-77). Монгол Данжурын 95-р ботид байгаа “Ил онолын чимгийн тайлбар хураасан утга” хэмээх номыг Сумади шасна дара орчуулжээ. *Сумади шасна дара* хэмээх санскрит үгийг төвдөөр орчуулбал Лувсанданзан гэсэн нэр болно. Хуучин цагийн монгол, төвд зохиолч орчуулагч нар нэрээ санскрит хэлээр орчуулж бичих явдал элбэг байсан. Монгол Данжураас гадна байгаа мөн номын төгсгөлийн үгэнд *“Үзэмчин Цэвдэн бэйлийн хошууны гүүш Лувсанданзан монголчлов”* гэж бичсэн байна. Монгол Данжурын 114-р ботийн дотор “Чарья аватарын тайлбар” гэдэг ном байна. Энэ номыг “Халх Зая бандидын (1642-1716) шавь номч цорж Лувсанданзан монголчлон орчуулсан” байна. Дээр дурдсан “Утайн гарчиг” гэдэг номыг мөн халх зая бандидын шавь гүүш Лувсанданзан орчуулсан юм.

Алдарт зохиолч Цахар гэвш Лувсанцүлтим (1740-1810) багадаа Ачит номын хаан Лувсанданзангаас сахил авсан гэж Цахар гэвшийн намтарт бичсэн байна.

“Эрдэнэ зуугийн намтар” хэмээх бичмэл номын дотор нэг Лувсанданзангийн тухай нэлээд бичсэн байна. Тэнд бичсэнээс үзвэл 1684 онд Энх-Амгалан хаан ачит зураач гэлэн Лувсанданзанд зарлигийн бичгийг авахуулан Далай ламд явуулсан байна. Шилийнголын чуулганы арван хошууны ноёд ачит цорж Лувсанданзанд Шилийнголын арван хошууны дотор явахдаа 12 улаа, гурван хонин шүүс хэрэглэх эрх олгож шар торгон дээр дарсан тамгатай бичиг өгч лам шавь болж явсан гэжээ. Мөн Лувсанданзан халх, ойрадын дайн

самуун дарагдсаны дараа 1701 оноос эхлэн хэдэн жил Эрдэнэзууг сэлбэх ажлыг удирдаж байжээ. Тэгээд Лувсанданзан Эрдэнэзуугийн IV ширээт болж суусан ба Өндөр гэгээний урьд төрлийн 16 дүрийг зурж бүтээсэн гэжээ. 1718 онд номч цорж Лувсанжанцан Эрдэнэзуугийн V ширээт байснаас үзэхэд Лувсанданзан түүнээс өмнө нас барсан буюу ширээнээс чөлөөлөгдсөн байна.

Бас Халхын Шива ширээт (Лувсаншива)-ийг зохиолоо бичихэд бичээч нь анагаах ухааны зэрэг номд мэргэжсэн гүүш Лувсанданзан гэдэг хүн байжээ. Мөн Шива ширээтэд хэдэн ном зохиохыг дуртгаж бичүүлсэн хүн нь Манж хааны VI гүнжээс төрсөн, Чингис язгуурт лхазун (агь үеийн) Лувсанданзаннамжил гэдэг хүн байжээ (Taube, 1966, №953, 1012, 2019, 2041, 2151).

Энэ лхазун Лувсанданзаннамжил бол Ш.Нацагдоржийн дурдсан лам мөн бололтой. Гэхдээ энэ лхазун ламын ном зохиосон баримт олдохгүй байна. Халхын Шива Ширээт бол Зая бандида Лувсанпринлайн шавь, XVIII зууны үеийн хүн, Төвд оронд олон жил сууж ном үзсэн, халх, ойрадын дайны үед ойрадод олздогдож Халиун зайсангийн малыг хариулж явсан, сүүлдээ Монгол Ганжурыг хянаж хэвлэхэд оролцсон, Юнхэгүн сүмийн Даа лам болж суусан сонин түүхтэй хүн билээ (Lokesh Chandra, 1963:42). Шива ширээтийн бичээч байсан гүүш Лувсанданзан бол анагаах ухаан зэрэг эрдэмд мэргэжсэн орчуулагч гүүш хүн байжээ. Энэ хүнийг мөн л судалж үзэх хэрэгтэй байна. Лувсанданзангийн “Алтан товч”-д бараглавал 1634 оныг хүртэлх явдлыг бичсэн байна. Тэгэхлээр Лувсанданзан бол XVII зууны дундуур үеийн хүн байх ёстой гээд XVIII зууны үеийн Лувсанданзангуудыг “Алтан товч”-ийг зохиосон Лувсанданзан биш гэх хандлага нилээд түүхч нарт байдаг. Миний санахад XVIII зууны үеийн зохиогч XVII зууны дундуур үеийг хүртэлх буюу Манжид дагахын өмнөх түүхийг бичээд цааш нь үргэлжлүүлэлгүй орхисон байж болно. Би ингэж бодоод XVII-XVIII зууны үеийн Лувсанданзан нарын тухай материалыг цуглуулсан билээ. Цааш нь Лувсанданзан нарын тухай мэдээг нэмж цуглуулах хэрэгтэй. Нэгэнт цуглуулсан материалаа харьцуулан судлах хэрэгтэй. Одоохондоо Үзэмчин Цэвдэн бэйлийн хошууны гүүшри Лувсанданзан, Халхын Зая бандидын шавь гүүшри Лувсанданзан, Цахар гэвшид сахил өгсөн ачит номын хаан Лувсанданзан, “Утайн гарчиг” бичсэн гүүшри Лувсанданзан эдгээр нь нэг хүн үү, олон өөр хүн үү? гэдгийг мэдэхгүй байна. Ялангуяа Үзэмчин Цэвдэн бэйлийн хошууны гүүшри Лувсанданзанг сайн судалж чадаагүй байна. Ийм учраас өгүүлэл бичих бэлтгэл ажлыг гүйцээгүй гэж үзээд материал цуглуулах, цуглуулсан материалаа судлах ажлыг үргэлжлүүлж байна.

“Алтан товч”-ийг хэнээс олж авсан тухай

Ж.Цэвээн гуай 1935-1936 онд Ленинградд “Монгольские летописи XVII века” гэдэг номоо зохиосон юм. Тэр номдоо Ж.Цэвээн гуай “Алтан товч”-ийг Жамъян гүн 1926 онд Сан бэйсийн хошууны юншөөв овгийн нэгэн тайжаас олж авсан гэж бичсэн билээ. Тэр тайжийн өвөг дээдэс нь XVII зууны үед Цахараас ирсэн гэж Ж.Цэвээн гуай бас тэмдэглэсэн билээ. Энэ мэдээг Жамъян гүнээс сонссон биз.

Юуны өмнө энэ мэдээг баримтлан мөрдөж тэр Юншөөв тайжийн нэрийг олох хэрэгтэй. Зохиолч С.Дашдэндэвийн ярьсан нь: “1926 оны намар Жамъян гүн Баянтүмэний хошуугаар суудлын машинтай яваад Улаанбаатарт буцсан. Би дунд сургуульд орох санаатай Жамъян гуайн машинд дайгдаж Улаанбаатарт ирсэн. Жамъян гуай замдаа ном судар эрж сураглаж явсан. Тугийн сүм дээр хоноод маргааш нь хоёр ваадан хэртэй ном данс аваад явсан” гэж яриу. Тэгэхлээр Жамъян гуай 1926 оны намар машинаар явахдаа Баянтүмэний хошууны Юншөөвийн нэгэн тайжаас “Алтан товч”-ийг олж авсан баймаар юм.

1954 онд би албан хэргээр Дорнод аймагт очоод алба ажлын завсар чөлөөгөөр Равдан зайсангийн хүү Гонгорыг сураглаж түүнээс “Алтан товч”-ийн тухай асууя гэж бодож байв.

Тэр Гонгор 1925 оны хавар надтай хамт Тамсагийн цэрэгт бичээч байсан, хуучин танил юм. Гонгорыг сураглавал түүнийг хөдөө Жаргалант суманд шилжиж очоод сууж байгаа гэж сонсов. Дорнод аймгийн төвөөс гарч Матад орох замдаа Жаргалант сумын нэг өвгөнтэй хөдөө уулзаж Гонгорыг сураглав. “Гонгорын нутаг хол, өөрөө Чойбалсан хот орсон байх магадгүй” гэж хэлэв. Тэр өвгөнийг сэхээтэн байдалтай хүн болохлоор “Жамьян гүн Алтан товчийг хэнээс авсан бол?” гэж асуув. Тэр өвгөн “Би мэдэхгүй. Энэ явдлыг сайд байсан Жигмидийн Алтангэрэл сайн мэднэ. Та түүнээс асуу” гэв. Ж.Алтангэрэл хаана байгааг асуувал тэр хэлэв: “Хэрлэнгээ уруудаад өртөө шахуу явбал тэднийд хүрнэ” гэж хэлэв. Би буцаж явах дургүй байв. Бас тэднийд очиход Ж.Алтангэрэл нь гэртээ байх ч юм уу? Үгүй ч юм уу? гэж эргэлзэж, “За больё. Гонгор, Алтангэрэл нартай сүүлд уулзъя” гэж бодоод Матад руу явсан билээ. Түүнээс хойш 1-2 жилийн дараа Равдангийн Гонгор Улаанбаатарт ирлээ. Түүнтэй уулзаж “Алтан товч”-ийн тухай асуусанд түүний хэлсэн нь: “Алтан товч”-ийг манайхнаас Баргын хөвөөт улаан хошууны Бүгшир гэдэг хүн аваад явжээ. Бүгшир эрдэмтэй хүн байсан. Бүгширийн ач Самбуу гэдэг ламд тэр “Алтан товч” байжээ. Найман сарын Ганжур гэдэг яармаг худалдааны үеэр Юншөөвийн Даарий тайж Баргад очоод тэр номыг олж иржээ. Тэгээд “Алтан товч” Даарий тайжийнд байсан юм. Жамьян гүнгийн захиалгаар үзэмчин зайсан Содномлхамжав авах гэж очиход Даарий тайж өгсөнгүй гэнэ. Содномлхамжав үзэмчин гэдэг хочтой байсан, чухамдаа жинхэнэ халх хүн. Тэгэхлээр Равдан зайсан Даарий тайжтай ярьснаас хойш Мөргөдөгийн Жамьяндагва гэдэг баян хүн “Алтан товч”-ийг Даарий тайжаас аваад хөсгөөр Хүрээ орохдоо Жамьян гүнд аваачиж өгсөн гэдэг. Манай эцэг Равдан тэгээд “Жамьянгийн эрүүнээс саллаа” гэж ярьж байсан. Ийм үгийг Гонгор надад ярьсан билээ. “Алтан товч”-ийг Жамьян гүн Даарий тайжаас авсан гэдэг Гонгорын үгийг би үнэмших боловч бусад зарим мэдээ нь эргэлзээтэй санагдахад энэ мэдээг өөр хүнээс лавлахад илүүдэхгүй гэж бодов. 1961 оны 7-р сард би Дорнод аймагт албан хэргээр очлоо. Сайд байсан Ж.Алтангэрэлтэй уулзах гэж Хэрлэнг уруудаж машинаар давхив. Замдаа хоньчин Дамбийжунай гэдэг хүнтэй уулзаж Ж.Алтангэрэлийг сураглав. Би түүнээс бас “Алтан товчоо” асуув. Түүний хэлсэн нь: “Жамьян гуайг энэ нутгаар явах үед би энд цэрэгт байсан. Жамьян гуай Даарий тайжаас нэг чухал номыг авсан гэж сонссон” гэж яриу. Цааш нь яваад Ж.Алтангэрэлийнд очив. Ж.Алтангэрэл эзгүй байв. Малаа хариулж явахад нь би түүнтэй хөдөө уулзаж, “Алтан товч”-ийг Жамьян гуайд өгсөн хүний тухай асуув. Түүний ярьсан нь: “Даарий дөнгөж амьд байхад нь Жамьян гуай Алтан товчийг түүнээс олж авсан гэж сонссон. Даарий тайж, Равдан зайсан хоёр их найз хүмүүс байсан. Жамьян гүн Равдан зайсангаар зуучлуулж Алтан товчийг авсан байх. Даарий бол Юншөөв овгийн тайж, дээд үеэ их сайн мэддэг, төөлүүр (нэрийн цэс) сайн мэддэг хүн байсан. Тайж нарын төөлүүрийг бараг цээжээр хэлдэг байсан. Даарий тайж бичигт сайн, тамганд түшмэлээр суудаг байсан” гэж яриу. Жамьян гүн “Алтан товч” -ийг Даарий тайжаас авсан бөгөөд Даарий тайж нь Юншөөвийн тайж гэдгийг мэдсэн боловч Жамсрангийн Цэвээн гуайн мэдээлсэн тэр Юншөөв тайж нь Цахараас гаралтай гэдэг үгийг магадалж чадаагүй байна. Жамьян гүн өөрөө Даарий тайжаас авсан уу, эсвэл Жамьяндагва хүргэж өгсөн үү гэдэг асуулт мөн мэдэгдэхгүй байна. Тэгтэл бас нэг Дамдин тайжийн нэр гарч ирлээ. Энэ тухай мэдээг бичье. Жамьян гүн тэр “Алтан товч”-ийг эрж сураглаж байсан тухай ямар нэгэн мэдээ улсын архивт байж магадгүй гэж бодоод улсын архивын материалыг сонирхдог байлаа. 1957 оны 11-р сард архивч Догсом Дорнод аймгийн Баянтүмэний хошууны 1926 оны албан хэргийг эмхэлж товъёглож байгаад Судар бичгийн хүрээлэнгийн дарга Жамьян гүнгээс 1926 оны 10-р сард Баянтүмэний хошууны тамгын газарт илгээсэн хуудсыг олжээ. Тэр хуудсанд бичсэн нь: “Тус хошууны хурц тайж Галдандашийн ач хүү Дамдин хэмээх хүнд Түмэдийн Алтан гэгээн хааны түүхийн зэрэг Монголын уг эхэд чухал холбогдолтой бичиг судар буй хэмээн сонсов. Түүнийг авчруулахаар зарлагыг явуулав. Түүнийг авахад үзэмчин хэмээх Содномлхамжав хэрэгтэй. Иймд түүнд уналга улаа олгоно уу?” гэжээ. Үүнийг мөн архивт материал эрж байсан С.Дашдэндэв надад хуулж өгсөн. Жамьян гүн 1926

оны намар (9-р сард) Баянтүмэнд машинаар явсныг зохиолч С.Дашдэндэвийн мэдээгээр дээр бичсэн билээ. Тэгэхлээр Жамьян гүн Баянтүмэнд явж ирээд мөн оны 10-р сард Дамдин тайжаас ном авахуулах гэж зарлага явуулсан шиг болж байна. Тэр авахуулах гэсэн ном нь “Алтан товч” биш, “Алтан гэгээн хааны түүх” гэдэг ном байна. Бас Даарий тайжаас ном авах гэсэн биш, Дамдин тайжаас ном авах гэсэн байна. Үүнд битүүлэг зүйл олон байна. Энэ бүгдийг шалгаж үзэх хэрэгтэй. Нэг өгүүлэл бичихийн тул 25 жил материал цуглууллаа. Гэвч өгүүлэл бичих гэхэд урьдчилсан судалгааны ажил арай бэлэн болоогүй байна. Урьдчилсан судалгааны ажил бэлэн болмогц Лувсанданзангийн тухай, мөн Жамьян гүн “Алтан товч”-ийг Даарий тайжаас авсан тухай өгүүлэл бичнэ гэж бодож байна. Би энд бэлэн болоогүй түүхий материалаа туршлага солилцох журмаар бичиж байна.

Амжилтгүй болсон туршлагаас

Би олон жил эрдэм шинжилгээний ажлыг хийхэд миний ажил дандаа сайн үр дүнтэй болж байсан биш, заримдаа алдаа гаргаж цагаа дэмий үрсэн удаа цөөнгүй билээ. Би энд амжилтгүй болсон нэг туршлагаа мөн өөрийн картаас хуулж бичье.

Гарди, могой хоёр дайсан болсон тухай Монголд олон сайхан үлгэр байдаг. Үүнээс заримыг товчилж хэлье. Урьд нэг гарди байжээ. Тэр гарди “Ямар амьтны цус хамгийн амттай болохыг мэдэж аваад тэр амьтныг идэж байя” гэж бодоод хэдгэнийг элчээр явуулжээ. Хэдгэнэ олон амьтны цусыг сорж амсаж үзвэл хүний цус хамгийн амттай байжээ, Үүнийг гардид хэлье гээд нисэж явтал замд нь хараацай дайралдаад хоёул ярьж гэнэ. “Хүний цус хамгийн амттай байна” гэж гардид хэлэх гэж яваагаа хэдгэнэ ярьжээ. Хараацай хүнд хайртай шувуу тул “Гарди хүний цус хамгийн амттайг мэдээд хүнийг идэх болбол дэлхий дээрх хүн барагдах болно” гэж бодоод хүнийг аврахын тул хэдгэнийн хэлийг тас хазаад зугтаажээ. Хэдгэнэ гардид очоод “Хүний цус сайхан” гэж хэлэх гэсэн боловч хэлгүй учраас хэлж чадахгүй дүнгэнээд байжээ. Тэгэхлээр хараацай нисэж очоод хэлмэрчлэх болжээ. “Энэ юу гэж дүнгэнээд байна гэж хараацайнаас гарди асуусанд хараацай “Могойн цус хамгийн амттай байна гэж байна” гэж худал хэлжээ. Гарди хараацайн үгийг итгэж могойг иддэг болжээ. Ингээд гарди, могой хоёр дайсан болсон юм” гэж ярьдаг.

Бас нэг монгол үлгэрийн товч агуулгыг бичье. Урьд нэг гардид гурван хүүхэн байжээ. Гарди хол юманд яваад гурван бүсгүйг гэртээ байхад холоос ирсэн нэг баатар тэднийд оржээ. Тэгэхэд нэг хүүхэн уйлж байжээ. Нөгөө хүүхэн дуулж байжээ. Гурав дахь хүүхэн инээж байжээ. Баатар эр тэднээс уйлж, дуулж, инээж байгаа учрыг асуувал, уйлж байгаа хүүхэн хэлжээ: “Аварга могой намайг өнөөдөр ирж иднэ. Би тэгээд уйлж байна” гэжээ. Дуулж байгаа хүүхэн хэлжээ: “Аварга могой намайг маргааш иднэ. Би тэгээд дуулж байна” гэжээ. Инээж байгаа хүүхэн хэлжээ: “Аварга могой намайг нөгөөдөр идэх юм. Миний идэгдэх өдөр хол байна гэж бодоод би инээж байна” гэжээ. Тэр баатар үдэш аварга могойг ирэхэд түүнийг алаад гардийн гурван хүүхний амийг аварсан байна. Гарди баярлаж баатарт унаа болж хүрэх газарт нь хүргэж өгсөн гэнэ. Энэ бол сонин гүн агуулгатай сайхан үлгэр юм. Шувуу, могой хоёрын дайсан бололцсон тухай үлгэр Америкийн уугуул хүмүүс ацтек нарын дотор байдаг. Мексик оронд дэлгэрсэн нэг домгийг орчуулан бичье. Хойд зүгээс, домогт Астлан орноос бололтой шинэ нүүдэлчин аймаг Мексикийн хөндийд нүүж ирэв. Тэднийг ацтекууд гэдэг байлаа. Эд нар бол хэдэн зуун жил үргэлжлэн цувж Мексикт нүүж ирсэн долоон Чичмек аймгийн сүүлийнх нь байлаа. Ацтекуудын зөнч мэргэн бөө тэргүүлэгч Хуитсилопочтли харьяат нараа нум сум хэрэглэж харвах ажилд сургаснаар барахгүй, ацтекууд аршийн ургамал дээр бүргэд суугаад могойг идэж байгаа газар дайралдвал тэнд суурьших хэрэгтэй гэж мэргэлэн айлдсан байжээ. Ацтекуудын нүүх замд гамшиг бэрхшээл олон тохиолдсон боловч чармайж өмнө зүг давшсаар уужим өн сайхан хөндийд ирсэнд, тэнд Тешкоко нуурын хөвөөнд бүргэд могойг идэж байгаатай дайралдаж тэнд нутагшин сууж

усанд хашилт далан хийж нийслэл Теночтитлан хотыг байгуулж бас орд, суварга, тэнгэрийн сүм зэргийг байгуулсан гэжээ. Цааш нь би шувуу, могой хоёрын дайсагнасан домгийг олон номоос хэдэн жил түүлээ. Эдгээр нь Ази, Америкийн ард түмний дотор өргөн дэлгэрсэн ижлэвтэр домог бөгөөд нэг гаралтай ч байж магадгүй гэж бодож байлаа. Тэгээд нэг удаа махчин шувууны судлалын ном уншиж байтал могой иддэг махчин шувуу дэлхий дээр газар бүр шахам байдаг гэж тэнд бичсэн байлаа. Тэгэхлээр могойг идэж байгаа махчин шувууг үзсэн аль ч газрын хүн ард шувуу, могой хоёрын дайсагнасан домог үлгэрийг зохиож болох юм гэж мэдлээ. Дээр дурдсан домгууд хоорондоо холбоогүй тус тусдаа биеэ дааж үүссэн байж болно гэж мэдлээ. Ингээд миний хэдэн жилийн хөдөлмөр олигтой үр дүнгүй болсонд би тэр картуудыг боогоод дээр нь *гарди, могой* гэж цохоод шүүгээний ёроолд хийсэн билээ. Энэ мэтийн амжилтгүй болсон ажил нилээд бий. Нэг зүйл дээр амжилтгүй болоход нөгөө зүйл дээр амжилт гарч болно. Эрдэм шинжилгээний ажилтан бол цөхрөлтгүй чармайж, цуцалтгүй ажиллах ёстой.

Номзүй

Taube M. *Tibetische Handchriften und Blockdrucke*. Wiesbaden, 1966.

Lokesh Chandra. *Materials for a History of Tibetan Literature*. Part 2. New-Delhi, 1963.

Жамцарано Ц.Ж. *Монгольские летописи XVII века*. М.-Л., 1936.

Шастина Н.П. *Лубсан Данзан. Алтан тобчи*. М., 1973.

Нацагдорж Ш. *Алтан товчийн зохиогчийн тухай* Шинжлэх ухаан, техник сэтгүүл. №1. Уб., 1958.

Шагдар Ц. *Алтан товч*. Уб., 1957.

Дамдинсүрэн Ц. 1964. *Рашааны дуслын төвд, монгол тайлбарууд*. Уб.,

Кузьминов В. 1968. *Тайна жеренов Майя*. М.,